


ОЮУ ТОЛГОЙН ТУХАЙ ТОВЧХОН



■ Оюу Толгой нь Монгол Улсын өмнөд хэсэг, Өмнөговь аймагт нийслэл Улаанбаатар хотоос 600 километр зайд орших дэлхийн хамгийн том ашиглалтад бэлтгэж буй алт, зэсийн орд юм.

■ Оюу Толгойн олборлолт 2012 онд ил уурхайгаас эхлэх бөгөөд жилд 450,000 тонн зэс, 330,000 унц алт үйлдвэрлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна. Ингэснээр дэлхийн томоохон зэс, алтны уурхайн нэг болно.

■ Оюу Толгой нь Монгол Улсын Засгийн газар, Айвенхоу Майнз болон Рио Тинто группын хамтарсан компани юм. Энэхүү төслийг Рио Тинто 2010 оны 10 дугаар сараас удирдаж эхэлсэн бөгөөд тус компани нь Айвенхоу Майнзын хувьцааны 48,5%-ийг эзэмшдэг.



Хаягдал өтгөрүүлэгч байгууламж



БАРИМТЫН ТОВЧООН

ЭДИЙН ЗАСГИЙН ҮР ӨГӨӨЖ

- Оюу Толгой бүрэн хүчин чадлаараа ажиллаж эхлэхэд Монгол Улсын Дотоодын нийт бүтээгдэхүүн гуравны нэгээр буюу 35%-иар өснө.
- Хараат бусаар хийгдсэн Эдийн засгийн нөлөөллийн үнэлгээнд дурдсанаар 2020 он гэхэд Монгол дахь бодит цалингийн дундаж хэмжээ нь Оюу Толгойг ашиглаагүй үетэй харьцуулбал 30%-иар өссөн байх тооцоо гарчээ.
- Монгол Улсын Засгийн газар уурхайн 34%-ийг эзэмшиж, татварын өмнөх ашгийн 59%-ийг авдаг бөгөөд бүтээн байгуулалт болон үйл ажиллагааны зардлыг хуваалцах үүргийг хүлээдэггүй. Орон нутгийн ханган нийлүүлэгч нарт төлж буй мөнгөн дүнг нийлүүлээд тооцвол нийт ашгийн 60-аас илүү хувь нь Монгол Улсад үлдэх юм.
- Олборлолтын үйл ажиллагаа эхлэхээс өмнө 5 тэрбум гаруй ам долларын хөрөнгө оруулалтыг уурхайд хийнэ.
- Төслийн санхүүжилтыг Олон улсын валютын сан, Европын сэргээн босголт, хөгжлийн банк болон томоохон банкуудын консорциум хийх юм. Энэ нь түүхэн дэхь хамгийн том олборлох салбарын төслийн санхүүжилт болж байна.





Оюу Толгой ХХК
Моннис цамхаг
Чингисийн өргөн чөлөө-15
Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар - 14240

Олон нийттэй харилцах хэлтэс
Утас: +976 11 331880
Факс: +976 11 331893
И-мэйл: OTLLCinfo@ot.mn
www.ot.mn